

ЯПОН УЛСЫН БАГА ДУНД АХЛАХ СУРГУУЛИУДЫН СУРГАЛТЫН СЭТГЭЛ ЗҮЙН БОЛОН МАТЕРИАЛЛАГ ОРЧИН БҮРДҮҮЛЭЛТ

СХД-ийн 67 дугаар сургуулийн сургалтын менежер
Д.Амархүү

ТАНИЛЦУУЛГА

- ✦ 2012 оны 06-р сарын 16-30-ны өдрүүдэд “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд Улаанбаатар, Сэлэнгэ, Булган, Дорнод, Завхан аймгийн 22 төлөөлөгч Япон оронд очиж, сургалтанд оролцон японы ахлах, дунд, бага сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлаад ирсэн юм. Япон улсын бага, дунд, ахлах сургуулиудад сургалтын материаллаг болон сэтгэл зүйн орчныг бүрдүүлэн ажиллаж байгаа арга туршлага, япон багш нарын өгсөн зөвлөмж, илгээсэн мэдээллийг та бүхэнтэй хуваалцаж байна.

Өөрийн ажилладаг СХД-ийн ЕБ-ын 67-р сургуулийн багш нартаа мэдээлэл хийж, Япон орны сургуулиудаас өөрийн сургууль дээрээ хэрэгжүүлж болох арга туршлагаас нь танилцууллаа. Мөн сурагчдыг бага наснаас нь эхлэн зөв хүн болгон төлөвшүүлэх үйл ажиллагааг чадварлаг зохион байгуулдаг арга туршлагатай багш нарын үйл ажиллагааг сурталчлан тайлбарлаж ялангуяа анги удирдсан багш нартаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөн үйл ажиллагаагаа явуулж байна. Багш нартаа Япон улсын сургуулиудын сургалтын орчин бүрдүүлэлтийн талаархи мэдээллийг уламжилъя

СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ -1

✖ 1. “Сургалтын чанар
багшаас хамаардаг” гэж юу
гэсэн үг вэ? гэдэгт анхаарлаа
хандуулдаг. Энэ нь

✖ Суралцагчдын өмнө зогсож
байгаа багш нь хамгийн их
нөлөө үзүүлдэг сургалтын
орчин байна гэсэн үг.

Хүүхдүүд нь багшийнхаа сайн талд татагдаж, би ч гэсэн ийм хүн болох юмсан гэж мөрөөддөг. Ер нь багш нараас багшийн ажилдаа хандах халуун сэтгэлд тулгуурласан “Гоо зүй, ёс зүйн өндөр мэдрэмж” “Өндөр түвшний мэргэшил” “Хүн чанар” –ыг шаарддаг.

“ГОО ЗҮЙ, ЁС ЗҮЙН ӨНДӨР МЭДРЭМЖ”

Багш нар нь өөр өөрийн хувийн огцлогтой, суралцагчид, олон эцэг эхчүүд болон орон нутгийн иргэдтэй өдөр тутамд харилцдаг Тэгэхэд тэдгээрийн үг, хандлага, нүүр царайны илэрхийллээс юуг мэдэрч чаддаг вэ? Тэр нь их чухал юм гэж үздэг.

“ӨНДӨР ТҮВШНИЙ МЭРГЭШИЛ”

“Багш” байгаагаас хойш,
хүүхдүүдэд буруу юм зааж
хэзээ ч болохгүй, Тиймээс
бид нар үргэлж “Юм сурахын
хувьд ч өндөр түвшинд
мэргэшсэн хүмүүс” байх
ёстой

“ХҮН ЧАНАР”

Бид нар хүмүүсээр багш гэж дуудуулдаг. “Багш” гэдэг нь хүндэтгэлийн нэрийдэл юм. Өөрийгөө хүмүүсээр хүндэтгэлийн нэрийдлээр дуудуулж байх, үнэ цэнэтэй хүн мөн болох эсэхийг өөрөөсөө дахин асууж, өөрийн байдлыг дахин хянаарай

ХҮҮХДҮҮД ИЙМ БАГШИД ХАЙРТАЙ

“Багш маань намайг баярлаж байгаа үед ч гуниглаж байгаа үед ч намайг дуудаад миний яриаг сонсдог.” “Багш аа та яагаад ингэж олон зүйл мэддэг вэ? “”гэж намайг асуухад “Яагаад гэвэл багш нь ч байнга сурч байгаа шүү дээ” гэж ярьсан. Тийм учраас би ч гэсэн хичээнэ ээ”

ХЭРВЭЭ БАГШ НЬ ИЙМ БАЙВАЛ ХЭЦҮҮ ЮМАА

- ✖ “Багш маань үргэлж “Завгүй , ажилтай” гээд л миний яриаг огт сонсож өгдөггүй ээ”
- ✖ “Хичээлдээ юм асуухад миний асуултаас бултчихаад тодорхой хариу хэлж өгөөгүй ээ
- ✖ “Юмаа сайн хурааж байгаарай” “Цэвэрлэгээ их чухал шүү” гэж хэлдэг боловч багшийн маань ширээ үргэлж замбараагүй байдаг.Цэвэрлэгээг ч гэсэн бид нартай хийлцэж өгдөггүй шүү”

- ✖ Япон орны сургуулиудад хүүхдүүд өөрсдөө цэвэрлэгээгээ хийдэг.
- ✖ Энэ бүхнээс дүгнэж үзэхэд **Хүүхдүүд маань өдөр тутам багшийгаа /таныг / ажигласаар өсөж хөгжиж байна шүү** гэдгийг сайн санаж ажиллаарай гэж зөвлөснийг санаарай. Сурагч бүр өөрсдөө ширээгээ арчих жижиг цагаан ууттай алчуурыг тогтмол авч явж, хэрэглэж хэвшсэн байна.



СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ

-2


БҮХ ХҮҮХДҮҮДИЙГ ТАЙВАН СУРАЛЦАЖ, ЧАДДАГ АНГИ ТАНХИМЫН ОРЧИНГ ХЭРХЭН БҮРДҮҮЛЭХ ВЭ?

- ✖ Хичээл тарсны дараах анги танхимынхаа байдлыг ажиглан хараарай. Сурагчид тань явсны дараа ч анги танхимд илч дулаан нь үлдсэн байдаг. Хүүхдүүдийн хөгжлийн байдал болон сэтгэлийн байдал ч тэнд харагддаг.

- ✘ Хичээл тарсны дараа багш ангидаа орж ирэхэд “Мэдээллийн самбарыг өчигдрийнхөөс илүү сайн арчсан байвал жижүүрийн ажил их чухал байдаг тухай бүх хүүхдүүдэд ярьж өгье” гэж бодоод түүнийгээ хэрэгжүүлээрэй.

- ✖ Мөн тухайн нэг сурагчийн хичээлийн хэрэглэгдхүүний шүүгээ нь их замбараагүй болоод байна. энэ сурагч маань яасан бол Энэ сурагчийг анхааралтай харж байх хэрэгтэй байна.” гэх мэтээр хичээл тарсны дараах анги танхимд хүүхдүүдээс багшид илгээсэн дохиогоор дүүрэн байдаг байна. Тэдгээрийг маргаашийн хичээлтэй холбож тусгаарай гэж зөвлөдөг.

✖ Тэгэхэд



гэсэн 3 өнцгөөс өөрийн анги танхимыг
орчинг шалгаж үзэхийг санал болгож байна.

1. АЮУЛГҮЙ БАЙДАЛ



- ✗ хайч, зураг дардаг, хадаас гэх мэтийг тогтсон газар нь хадгалсан байгаа эсэх
- ✗ Зурагт болон тавиур, дээрээс юм унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байгаа эсэх
- ✗ анги танхимын урьд хэсэгт сурагчдын явж гарах маршрутын зургийг байрлуулсан эсэх /зураг дээр бага ангийн сурагчид үдийн цайгаа ууж байгаа байдал. Жижүүр сурагчид нь бусад сурагчдадаа үйлчилж зохион байгуулдаг юум байна./





2. СЭТГЭЛ ТАЙВАН БАЙДАЛ

- ✖ Багш найз нөхөдтэйгөө мэндэлдэг болон бусдыг хайрлах дулаан үгээр хоорондоо харилцдаг эсэх
- ✖ Ирээгүй хүүхэд, хичээл тарахаасаа эрт явсан хүүхдийн ширээ нь эмх цэгцтэй байгаа эсэх
- ✖ Хүүхдүүдийн бүтээл болон хүүхдүүдэд харьяалагдах зүйлтэй нямбай харьцдаг эсэх

3.ТАВ ТУХТАЙ БАЙДАЛ

- ✘ Анги танхимын урд талд хадсан зүйлс нь хүүхдүүдийн хичээлд анхаарал хандуулахад саад болохгүй байгаа эсэх /хэт олон биш, ер нь чимэглэлгүй үсгээр бичигдсэн байвал зүгээр гэж зөвлөсөн/
- ✘ Хогийн саванд хичээлийн ТӨМ гэх мэтийг хийгээгүй байгаа эсэх
- ✘ Хананд хадсан зүйлийн дөрвөн өнцгийг зураг дардаг хадаас гэх мэтээр тогтоосон байгаа эсэх
- ✘ ургамал болон амьтан амьд сэргэлэн байгаа эсэх цэцгийн ваар болон аквариум нь цэвэрхан байгаа эсэх
- ✘ шүүгээ тавиурын ном хэвлэл цэгцтэй байгаа эсэх /хог хаягдал/ зэргийг нарийн шалгаж сурагчидтайгаа хамтран ажилладаг юум байна

ЭНДЭЭС ДҮГНЭВЭЛ:

- ✖ Анги танхимдаа хүсүүштай орчин бүрдүүлэх, явцад багшийн зүгээс хүүхдүүддээ заах ёстой зүйл байвал сайн зааж өгч байх хэрэгтэй Тэгсний үндсэн дээр өөрсдийн амьдралын тав тухтай орчинг багш хүүхдүүд хамтдаа бүрдүүлж явах хандлага чухал байна

СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ -3

ХҮҮХДҮҮДИЙГ БИЕ БИЕНЭЭС НЬ СУРАЛЦАЖ ЧАДДАГ АНГИЙН УУР АМЬСГАЛЫГ ҮҮСГЭХ

- ✖ Сургуулийн давуу тал нь “хамт суралцах найз нөхөдтэй байгаа” явдал юм. тэр сайн талыг бүрэн дүүрэн харуулахын тулд ангидаа улам сайн уур амьсгалыг бий болгох явдал гэж үздэг. жишээ нь: Багш нар хичээл зааж байхдаа сурагчдаас дараах байдлаар асуух нь олонтаа байдаг. Жишээ нь:

Болд багш:
Энэ бодлогыг
бодож чадсан
хүүхэд байна уу?
Мэдсэн
зүйлээ/хийж
чадсан зүйлээ/
яриарай

Бат багш:
Ойлгож чадахгүй
хэцүүдэж байгаа
хүүхэд байна уу?
Ойлгохгүй, хэцүү
төвөгтэй санагдаж
байгаа зүйлээ
яриарай.

Болд багшийн
сайн тал: “хийж
чадсан”
“ойлгосон ”
гэснийг хүлээн
аваад түүнийг
хамт суралцаж
буй бусад
хүүхдүүдэд
түгээн
дэлгэрүүлэх гэж
байна.

Бат багшийн сайн
тал: Хүүхдүүдийн
“ойлгохгүй байна”
“Хэцүүдэж байна”
гэснийг
анхааралтай
сонсож, түүнийг
үндэслээд
“Чадсан,
ойлгосон” байдал
руу чиглүүлэх гэж
байна.

- ✖ Энд зөвхөн Болд багшийнх шиг асуултыг асууж байвал зарим бүдэрч байгаа хүүхдүүдийг хичээлдээ сонирхолгүй болгоход хүргэх тохиолдол бийг анхаарах ёстой. Туршлагатай багш нарын нандигнаж ирсэн **“ХИЧЭЭЛИЙН ТАНХИМ БОЛ АЛДАА ГАРГАДАГ ТАЛБАЙ МӨН ШҮҮ”** гэсэн үг нь багш ангиа болон хичээлээ зохион байгуулахдаа баримтлах “Багшийн санаж явах ёстой үг” гэж ойлгомоор байна.

- ✖ Хүүхдүүд нь ойлгосон бол “Ойлгосон” гэж хэлээд хэрвээ ойлгохгүй байвал “Ойлгохгүй” гэж хэлж чаддаг байх хэрэгтэй. Яаж хэлсэн ч хэлснийгээ хүлээн авч өгдөг багш л байвал хүүхдүүд нь санаа бодлоо сэтгэл тайван илэрхийлж чаддаг болж, хичээл нь идэвхжиж, хамт суралцъя гэсэн уур амьсгал бий болдог байна. Иймээс Болд болон Бат багш тус бүрийн сайн талын аль алийг нь адил тэгш эзэмшмээр байна гэж дүгнэж болно.

СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ

-4

ХҮҮХДҮҮДИЙГ ГЭРТЭЭ ХИЧЭЭЛЭЭ ХИЙЖ ХЭВШҮҮЛЭХЭД ЯАХ ВЭ?.....

- ✖ Хүүхдүүдийг гэртээ хичээл хийлгэе гэхэд зөвхөн “Хичээлээ хий” гэснээр хэвшдэггүй. Хүүхдүүдийн нас, ангиар нь дэмжих, арга нь өөр өөр болдог ч эцэг эхийн зүгээс хүүхдээ дэмжиж өгөх зайлшгүй шаардлагатай юм. Анги удирдсан багшаас эцэг эхчүүдэд хандаж, “Хүүхдийн эцэг эхээрээ хийлгэх дуртай зүйл болон “Хүүхдэдээ хэрхэн хандаж ярих вэ?”

ГЭХ МЭТ МЭДЭЭЛЛИЙГ, ХҮҮХДҮҮДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВШИНТЭЙ НЬ ТОХИРСОН
ХАРИЛЦААНЫ АРГЫН ЖИШЭЭГ, БҮЛЭГ
БОЛОН АНГИЙН ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ,
ГАНЦААРЧИЛСАН УУЛЗАЛТ, АНГИЙН
СОНИН, МЭДЭЭ ГЭХ МЭТИЙН
БОЛОМЖИЙГ АШИГЛАН ИДЭВХТЭЙ
ЦАЦАЖ БАЙВАЛ ЗҮГЭЭР ГЭЖ ЗӨВЛӨЖ
БАЙНА.

- ✖ Бага сургуулийн 1-2-р анги гэх мэтийн хүүхдүүд бие дааж ганцаараа хичээл хийхэд их төвөгтэй байдаг. Хэдийгээр богино хугацаагаар ч гэсэн гэрийнхэнтэйгээ хамт хичээл хийвэл үлдэцтэй, бас гэртээ хичээл хийж хэвшүүлэх боломжтой.

- ✖ Хүүхдүүд /дунд сургуулийн сурагч байсан ч / эцэг эхээрээ магтуулж, хүлээн зөвшөөрүүлэхээс илүү урам өгөх зүйл алга. Ингэснээр хүүхдэд юм хийх юмсан гэж зорьдог болно.

- ✖ Бага ангийн хүүхдийн хувьд эцэг эхийн шууд оролцоо чухал байдаг. Хүүхдийг анги дэвших тусмаа гэрийнхний үүрэг нь өөр болж, хамт хийлцэж дэмжихээс бага багаар ганцаараа хийхийг дэмжихэд шилжиж, хүүхдийн байдлыг анхааран харж, түшиж дэмжлэг болно.

- ✖ **Харин хөгжлийн аль ч түвшинд эцэг эхийн хүүхдэдээ сэтгэлээ хандуулж байх нь их чухал гэдэг нь ялгаагүй байна.**
- ✖ Хүүхдүүдээс хурааж авсан дэвтэр болон тараах материалуудыг заавал шалгаж, багшийн санал гэх мэтийг бичээд хүүхдүүдэд буцааж өгөөрэй. Багш нарыг хүүхдүүддээ ингэж хандаж ажилласны эцэст эцэг эхчүүдийн итгэлийг олж чаддаг.







- ✖ Манай төлөөлөгч багш нар байгалийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх төв дээр очиж сургалтанд суухад гарын доорхи материал ашиглан бяцхан цахилгааны багаж хийлгэх дадлага ажлыг хийлгэсэн Бидэнд маш их сонирхолтой байсан. Манай багш нар ч гэсэн ийм сонирхолтой туршилтыг олноор хийж байвал хичээл маань улам л үр өгөөжтэй сонирхолтой байна.



Хигаши Ямато ахлах сургууль дээр очиж, ахлах ангид мэдээлэл зүйн хичээлийг заах арга зүйтэй танилцлаа. Зураг дээр /мэдээлэл зүйн багшийн удирдлагын ширээ/



- ✖ Хигаши Ямато ахлах сургуулийн сурагчид мэдээлэл зүйн хичээл дээрээ /2 сурагчийн дунд багшийн удирдлагын 1 компьютер ажиллаж байна./



- ✖ Сурагчид хичээл дээрээ ажилласан ажлын хуудсаа хураалгах шаардлагатай үед багшийн ширээн дээр тусгайлан бэлтгэсэн сагсан дотор хийгээд завсарладаг.



- ✗ Сургуулийн сурагчид, ялангуяа бага ангийн сурагчид улирал тутамд
- ✗ 1-рт сурлага
- ✗ 2-рт хүмүүжил
- ✗ 3-рт бусад гэсэн чиглэлээр маш тодорхой зорилго тавьж, түүнийгээ биелүүлж ажилладаг Сурагчид тавьсан зорилгоо ангийнхаа хананд нэгтгэн бичиж байрлуулсан байна.

- ✖ Сагамихара хотын Оонодай-Чүүоо бага сургуулийн 2012 оны боловсролын төлөвлөгөөний уриа нь
- ✖ Хүүхдүүд бие биентэйгээ дотносож харилцан суралцах сургууль
- ✖ Уужим сэтгэлтэй тэвчээртэй хичээдэг, хичээнгүйлэн суралцаж чаддаг хүүхдүүд төлөвшүүлэх гэж тодорхойлсон байна.

- ✘ Сургуулийн боловсролын зорилт нь:
- ✘ Ёс зүй гоо зүйн өндөр мэдрэмжтэй, хүн болгон төлөвшүүлэхийн тулд өөрөө бие даан суралцаж, сэтгэн бодож, шийдвэрлэж чаддаг хүүхэд болгож хөгжүүлэх гэж дэвшүүлсэн байна.
- ✘ Сургуулийн менежментийн үндсэн үзэл санаа нь хүүхэд төвтэй сургууль байх явдал юм. Сургуулийг сургалтын үйл ажиллагааны талбар мөн гэж үздэг байна.

УУЖИМ СЭТГЭЛТЭЙ ХҮҮХЭД

- ✖ Бусадтай өөрөөсөө чанга дуугаар мэндлэж чаддаг хүүхэд
- ✖ Бусдын байр суурийг хүндэтгэж, халамжилж чаддаг хүүхэд
- ✖ Бие биеийн хүний эрх ба ялгаатай талуудыг хүлээн зөвшөөрч хүндэтгэж чаддаг хүүхэд
- ✖ Бие биеэ хүлээн зөвшөөрч, дэмжиж, хамтран ажиллаж чаддаг хүүхэд
- ✖ Сургуулийн амьдралын дүрэм журмыг дагаж, өөртөө хяналттай байж чаддаг хүүхэд
- ✖ Хүн болон аливаа зүйлд талархах, сэтгэлтэй хүүхэд
- ✖ Байгалийг хайрлан хамгаалж арчилж чаддаг хүүхэд

ТЭВЧЭЭРТЭЙ ХИЧЭЭДЭГ ХҮҮХЭД

- ✖ Амь насны үнэ цэнийг мэддэг, өөрөө болон бусдын аюулгүй байдалд анхаарч чаддаг хүүхэд
- ✖ Эрүүл бие сэтгэлтэй, өөдрөг, чөлөөтэй бие дааж чаддаг хүүхэд
- ✖ Найз нөхөдтэйгөө хамтран ажиллаж, өөрийн санаачлагатай байж, юмыг хариуцлагатай гүйцээж чаддаг хүүхэд
- ✖ Өөрийн гэсэн зорилтыг биелүүлэхийн тулд тасралтгүй хичээн чармайдаг хүүхэд
- ✖ Ур чадвараа хөгжүүлэхийн тулд юм бүрийг хичээн чармайж, хийж чаддаг хүүхэд

ХИЧЭЭНГҮЙЛЭН СУРАЛЦДАГ ХҮҮХЭД

- ✖ Суурь, үндсэн мэдлэгийг тууштай эзэмшиж чаддаг хүүхэд
- ✖ Бүтээлч сэтгэлгээтэй, юмыг олон талаас нь боддог, өөрийн давуу талуудыг хөгжүүлж явдаг хүүхэд
- ✖ Олон туршлага хуримтлуулж, өөрийн идэвхи санаачлагатай суралцдаг хүүхэд
- ✖ Сурч мэдсэн зүйлээ өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж чаддаг хүүхэд
- ✖ Бусдын яриаг дуустал нь сонсч, өөрийн гэсэн бодол саналыг илэрхийлж чаддаг хүүхэд
- ✖ Өөрөө сэтгэн бодож, асуудлыг шийдвэрлэх аргыг олж чаддаг хүүхэд
- ✖ Асуудлыг зөв шийдвэрлэж хэрэгжүүлж чаддаг хүүхэд



- ✖ Бага сургуулийн сурагчид өдөр бүр 10 минутын уншлагын цагтай. 10 минутын уншлагын цагийн чанарыг дээшлүүлснээр хүүхдүүдийн сэтгэлд шим тэжээл өгч амьдралдаа тайван хандах хандлагтай болно гэж үздэг.

БАГА СУРГУУЛИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС



- ✖ Бага сургуульд нь ёс зүйн зөвлөл ажилладаг. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 1-6-р ангийн багш нарын төлөөлөл, мөн биеийн тамир, дуу хөгжмийн мэргэжлийн багш нар ажилладаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КАБИНЕТ



- ✖ Сургууль бүр эрүүл мэндийн кабинеттэй. Кабинетын зүгээс сурагчдын дунд сургалтыг байнга зохион байгуулдаг. Жишээ нь ахмад настай хүнийг яаж асарч халамжлах вэ? ГЭХ МЭТ



- ✖ Эрүүл мэндийн кабинетийн хананд амьдрал ахуйд хэрэглэгдэх зайлшгүй мэдвэл зохих мэдээллүүлийг өнгөт үзүүлэнгээр харуулж хадсан байдаг.

АНГИЙН УРД ХЭСГИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ



- ✖ Бага дунд ахлах ангийн урьд хэсгийн харагдах ерөнхий байдал.
- ✖ Аль ч сургуулийн ангиудад сургалтын хэрэглэгдхүүн маш элбэг байдаг. Анги бүр телевизтэй. Сургалтын хэрэглэгдхүүнүүд маш эмх цэгцтэй байрласан байдаг.

БАГА АНГИЙН ХӨГЖМИЙН ХИЧЭЭЛ



- ✖ Бага ангийн сурагчдын дуу хөгжмийн хичээл явагдаж байгаа нь:
- ✖ Энэ үед анги удирдсан багш нь сурагчидтайгаа хамт байдаг.

БАГШ НАРЫН АЖЛЫН ӨРӨӨ



- ✖ Япон сургуулийн багш нарын ажлын өрөө
- ✖ Хичээлийн дараа багш нар нь ажлынхаа өрөөнд сууж дараагийнхаа хичээлд бэлтгэж хэвшсэн байна.

Өөрийгөө нээж хөгжье
Өрөөл бусдад түгээж хөгжье
Өсвөр үеэ таньж хөгжүүлье

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА
